



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2021 оны 07 сарын 08 өдөр

Дугаар 305

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх заалт, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 4 дэх заалт, Төв аймгийн Засаг даргын 2019 оны А/576 дугаар захирамж, Өмнөговь аймгийн Засаг даргын 2020 оны А/1321 дүгээр захирамж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.10, 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Өмнөговь, Төв аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр бий болсон нийт 45,875,225.00 (дөчин таван сая найман зуун далан таван мянга хоёр зуун хорин таван) төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу төрийн өмчид хүлээн авч, Улсын бүртгэлийн ерөнхий газрын харьяа Өмнөговь, Төв аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст эзэмшүүлж, үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Д.Дэлгэрсайхан болон тогтоолд заасан байгууллагын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д. Нарангэрэл

132001274

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн
305 дугаар тогтоолын хавсралт



ӨМНӨГОВЬ, ТӨВ АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР
БИЙ БОЛСОН ХӨРӨНГИЙГ ТӨРИЙН ӨМЧИД ХҮЛЭЭН АВЧ, УЛСЫН
БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬЯА ӨМНӨГОВЬ, ТӨВ АЙМАГ ДАХЬ
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭСТ БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, марк	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын нийт үнэ (төгрөг)
1.Өмнөговь аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс				
1	Скайнер (Epson DS-780N)	2	2,900,000.00	5,800,000.00
2	Скайнер (Epson DS-530)	2	2,050,000.00	4,100,000.00
	Дүн			9,900,000.00
2.Төв аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс				
1	Автомашин, приус-30	1	17,140,563.00	17,140,563.00
2	Нягтруулсан шүүгээ (архив)	20	941,733.10	18,834,662.00
	Дүн			35,975,225.00
	Нийт дүн			45,875,225.00